



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Э.Энхцэцэг
Аудитор:		Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn
		Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.21 № 1-6/59

танай _____ -ны № _____ -т

АЙРАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ



010020778

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	151.5	135.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,811.1	3,324.8
	Нийт хөрөнгийн дүн	2,962.6	3,460.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,962.6	3,460.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,962.6	3,460.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,041.6	1,181.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	660.9	683.4
	Үйл ажиллагааны үр дүн	380.7	498.0
	Үйл ажиллагааны бус үр дүн	-5.1	-1.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	375.6	496.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	623.9	429.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	484.7	399.5
	Үйл ажиллагааны ЦМГ	139.2	10.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-139.2	-10.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	496.7	496.7
	Эцсийн үлдэгдэл	3,460.3	3,958.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	371.7	377.5
	Урсгал зардал	371.7	377.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	371.7	377.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	367.9	370.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	3.8	6.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Айраг сумын Засаг даргын Тамгын газар нь зорилгоо дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйлчилгээг хуульд нийцүүлэн ил тод хөнгөн шуурхай явуулахын зэрэгцээ нутаг дэвсгэрийн зохистой байршил, байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн давуу талд тулгуурлан сумаа нийгэм эдийн засгийн бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэн ажиллах.

Байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилт:

- “Ковид-19” халдварт цар тахал шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёл, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулж улс, тив дэлхийн хэмжээнд хүрэх урлаг, спортын авьяастнуудыг олноор төрүүлэн гаргаж олон нийтэд гоо зүй, ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэх;

- Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааны түвшинг дээшлүүлэх;
- Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх;
- Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар хүртээмжийг сайжруулах, малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх, газар тариаланг дэмжих төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Газрын харилцааны салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;
- Сумын нутаг дэвсгэрт байгаа Улсын тусгай болон орон нутгийн хамгаалалттай газар, аймаг сумын байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулан орон нутагтаа тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээг иргэдийн оролцоонд тулгуурласан, ил тод, нээлттэй, хуулийг дээдэлсэн, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, төрийн албыг төлөвшүүлэх.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 1 мэдээлэл байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 11.0 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 11.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 3.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.
2. Машин тоног төхөөрөмжийн дансанд 0.1 сая, програм хангамжийн дансанд 0.2 сая нийт 0.3 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсоныг залруулав.

3. Данс бүртгэлтэй 170.8 сая төгрөгийн 24 Газарт 7.0 сая төгрөгийн элэгдлийг тооцсоныг залруулав.

Зөвлөмж

1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2021 оны А/43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, 4.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2021 оны А/43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

5.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

5.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	11.0	3	11.0	-	-	-	-	1	-
	НИЙТ	4	11.0	3	11.0	-	-	-	-	1	-